



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/28

Улаанбаатар хот

Нийслэлийн Ерөнхий боловсролын  
Эрдмийн Ундраа цогцолбор сургуулийн  
данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/15 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр “Улаанбаатар хотын Цэвэр агаар нэмэлт санхүүжилтийн төсөл”-ийн хүрээнд 77 дугаар сургуульд хийгдсэн барилгын гадна дулаан хамгаалалтын ажлын гүйцэтгэлийн дүн 886,438,195 (найман зуун наян зургаан сая дөрвөн зуун гучин найман мянга нэг зуун ерэн тав) төгрөгөөр барилгын бүртгэлийн үнийг нэмэгдүүлж бүртгэхийг Эрдмийн Ундраа цогцолбор сургууль (Б.Наранбаатар)-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Эрдмийн Ундраа цогцолбор сургууль (Б.Наранбаатар)-д үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэст даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *В.ОЮУМАА* В.ОЮУМАА



1150500089

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын  
2024 оны ~~02~~ дугаар сарын ~~15~~ -ний өдрийн  
*A/28* дугаар тушаалын хавсралт



### Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн Ерөнхий боловсролын Эрдмийн Ундраа цогцолбор сургууль

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад авсан он	Чанар байдал	Гүйцэтгэлийн дүн	Эх үүсвэрээр	
						Нэр	Эх үүсвэр
1	Улаанбаатар хотын Цэвэр агаар нэмэлт санхүүжилтийн төсөл 77 дугаар сургуулийн барилгын дулаан хамгаалалтын ажил	Их засвар	2023	сайн	886,438,195.0	Дэлхийн банкны санхүүжилттэй "Улаанбаатар хотын Цэвэр агаар нэмэлт санхүүжилтийн төсөл"	Төсөл, хөтөлбөр
<b>Барилгын бүртгэлийн үнийг нэмэгдүүлэх дүн</b>					<b>886,438,195.0</b>		